



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/119

Мандалговь

“Бөмбүүлэй” хамтлагт дэмжлэг
үзүүлэх тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 а, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн 5 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. “Шувуухай нас” 2019 улсын уралдаанд оролцохоор шалгарсан 4 дүгээр цэцэрлэгийн “Бөмбүүлэй” хамтлагт дэмжлэг үзүүлсүгэй.

Хоёр. Дэмжлэгт шаардагдах 300000 (гурван зуун мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190331